



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр "Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амжиргааг сайжруулах" МОН-9192 төслийн хүрээнд бий болсон 800 м.кв талбайтай, нийт 1,148,000,000.00 (нэг тэрбум нэг зуун дөчин найман сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан "Дэвшилтэт технологийн өвлийн хүлэмжийг "Хөдөө аж ахуйн корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, "Хөдөө аж ахуйн корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

137000045
1-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 01 дугаар сарын 09-ны өдрийн
017 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИИ БОЛСОН
ХӨДӨӨ АЖ АХУЙН КОРПОРАЦИ ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИД
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Бүртгэлд тусгах хөрөнгийн нэр, хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Хөрөнгийн дүн (төгрөг)	Ажлын хэсгийн хүлээн	
						Огноо	Дугаар
		Барилга байгууламж					
1	Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл - МОН-9192	Өвлийн шилэн хүлэмжний барилга	м.кв	800	880,000,000.00	2024.12.25	T241223/05-686
		Машин тоног төхөөрөмж					
2		Дулаан үзелийн систем (4 ш насос бүхий)	зангилаа	1	68,000,000.00		
3		Цахилгааны холболт удирдлагын систем	иж бүрдэл	1	76,000,000.00		
4		Мананжуулагч	иж бүрдэл	1	18,500,000.00		
5		Хөргүүр (багтаамж-1400л)	ш	1	3,500,000.00		
6		Нүүрстөрөгчөөр баяжуулагч тоног төхөөрөмж	иж бүрдэл	1	14,500,000.00		
7		Хүлэмжийн автомат удирдлагын систем (компьютерийн хамт)	иж бүрдэл	1	40,050,000.00		
		Тавилга, эд хогшил					
8		Тэргэнцэр (2 м өргөнтэй)	ш	1	2,800,000.00		
9		Үрсэлгээний ширээ	ш	3	2,850,000.00		
10		Усны сав (16м.куб)	ш	1	5,800,000.00		
11	Таримлын тавиур	м	400	32,000,000.00			
	Хангамжийн зүйлс						
12	Хөрс	ширхэг	400	4,000,000.00			
	НИЙТ ДҮН			1,148,000,000.00 (нэг тэрбум нэг зуун дөчин найман сая)			